



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН
ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 238

Мандалговь

┌ Хөрөнгө дуудлага худалдаагаар худалдах, ┐
баланс ба баланст шилжүүлэх,
акталж устгах зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 31 дүгээр зүйл, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам"-ын 3.1.б, 3.1.д, 3.2.6.а, 5 дугаар зүйлийн 5.1 заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Баянжаргалан сумын цэцэрлэг, сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгийг хавсралт 1-ийн дагуу акталж, хөрөнгө актлах ажлыг сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байг, улж, хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлээс хасахыг холбогдох байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

2. Баянжаргалан сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 50'951'700 /тавин сая есөн зуун тавин нэгэн мянга долоон зуу/ төгрөгийн анхны өртөгтэй, 19'405'300 /арван есөн сая дөрвөн зуун таван мянга гурван зуу/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй барилгуудыг дуудлага худалдаагаар худалдах үнийн доод хязгаарыг хавсралт 2-ын дагуу тогтоож дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.


3. Баянжаргалан сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 13'877'600 /арван гурван сая найман зуун далан долоон мянга зургаан зуу/ төгрөгийн анхны өртөгтэй, 4'538'800 /дөрвөн сая таван зуун гуравдугаар таван мянга найман зуу/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг хавсралт 3-ын дагуу Баяндэлгэрэх хоршоонд балансаас баланст шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

4. Шилжүүлсэн болон худалдсан хөрөнгийг зохих хууль, журмын дагуу данс бүртгэлээс хасч, зочид буудлын барилгын доорх газрыг чөлөөлүүлж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Баянжаргалан сумын ЗДТГ-ын дарга Т.Цэвэлмаад даалгасугай.

5. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ



0100400

Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 10 сарын
02 өдрийн 238-р тогтоолын хавсралт 1

Акталж устгах барилга байгууламж, тээврийн хэрэгсэл

1. Барилга байгууламж

№	Эзэмшигч байгууллага	Барилга байгууламжын нэр	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ	Үлдэгдэл өртөг
1	Цэцэрлэг	Түлшний склад	1960	975'200	0
2	Сургууль	6 настын бие засах газар	2008	2'836'500	472'800
3		Агуулах	1957	4'131'000	275'400
ДҮН				7'942'700	748'200

2. Тээврийн хэрэгсэл

№	Эзэмшигч байгууллага	Тээврийн хэрэгслийн төрөл	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ	Үлдэгдэл өртөг
1	ЗДТГ	Бага оврын трактор	2008	1'910'000	0
ДҮН				1'910'000	0

Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 10 сарын
06 өдрийн 238-р тогтоолын хавсралт 2

Худалдах хөрөнгийн жагсаалт

№	Барилга байгууламжын нэр	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ	Үлдэгдэл өртөг	Худалдах үнийн доод хязгаар
1	1-р багийн контор	1997	15'321'200	8'623'300	500'000
2	Зочид буудал	1969	19'130'800	5'174'900	5'174'000
3	Халуун ус	1986	16'499'700	5'607'100	5'607'100
ДҮН			50'951'700	19'405'300	5'674'000

Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 10 сарын
06 өдрийн 938-р тогтоолын хавсралт 3

Балансаас баланст шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Барилга байгууламжын нэр	Байршил	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ	Үлдэгдэл өртөг
1	2 машины граж	Сумын төвөөс хойно	1980	3'921'500	352'300
2	2-р багийн контор	Энгэр-ус	1978	9956100	4186500
3	Нийт дүн			13'877'600	4'538'800